

**ШҮҮХИЙН БУС ЖУРМААР ӨР БАРАГДУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛАХ
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

ЗАХИАЛАГЧ:
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ

ГҮЙЦЭТГЭГЧ:
Г.ХАЛИУНАА

УЛААНБААТАР ХОТ

АГУУЛГА

Ерөнхий зүйл

Нэг.Шүүхийн бус журмаар өр барагдуулах үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн төсөлд үнэлгээ хийх шалгуур үзүүлэлтийг сонгох:

- 1.Зорилгод хүрэх байдал
- 2.Ойлгомжтой байдал
- 3.Хүлээн зөвшөөрөгдөх байдал
- 4.Харилцан уялдаа

Хоёр.Хуулийн төслийн үр нөлөө үнэлэх хэсгээ тогтоох:

- 1.Зорилгод хүрэх байдал
- 2.Ойлгомжтой байдал
- 3.Хүлээн зөвшөөрөгдөх байдал
- 4.Харилцан уялдаа

Гурав.Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх.

Дөрөв. Хуулийн төслийн үр дүнг үнэлж, зөвлөмж өгөх:

- 4.1.Үр дүнг баримтжуулах;
- 4.2.Үнэлэлт, дүгнэлт;
- 4.3.Зөвлөмж өгөх.

Тав.Ашигласан материалын жагсаалт, хавсралт.

ШҮҮХИЙН БУС ЖУРМААР ӨР БАРАГДУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Энэхүү үнэлгээний ажлын гол зорилго нь Шүүхийн бус журмаар өр барагдуулах үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн төслийн зохицуулалт /зүйл, хэсэг, заалт/-д тодорхой шалгуур үзүүлэлтийн дагуу дүн шинжилгээ хийх, үр нөлөөг тооцож, давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, хуулийн зохицуулалтыг ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулах, улмаар хуулийн төслийн чанарыг сайжруулахад оршино.

Шүүхийн бус журмаар өр барагдуулах үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн төсөл /цаашид “хуулийн төсөл” гэх/-ийн зохицуулалтын үр нөлөөг үнэлэхдээ Хууль тогтоомжийн тухай хууль¹, “Хуулийн төслийн үр нөлөө үнэлэх аргачлал”² /цаашид “аргачлал” гэх/-д заасны дагуу дараах үе шаттайгаар хийлээ:

- 1.1.Шалгуур үзүүлэлтийг сонгох;
- 1.2.Хуулийн төслөөс үр нөлөө үнэлэх хэсгээ тогтоох;
- 1.3.Шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
- 1.4.Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.

Үнэлгээг Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн боловсруулсан хуулийн төслийн эхний хувилбарт хийсэн болно.

НЭГ.ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ

Хуулийн төслийн үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэхдээ хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан аргачлалд дурдсан нийт 6 шалгуур үзүүлэлтээс дараах 4 шалгуур үзүүлэлтийг сонголоо. Үүнд:

- 1.Зорилгод хүрэх байдал
- 2.Ойлгомжтой байдал
- 3.Хүлээн зөвшөөрөгдөх байдал
- 4.Харилцан уялдаа

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийг хуулийн төслийн зохицуулалтууд нь хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хуулийн төслийг боловсруулах болсон хэрэгцээ, шаардлагад нийцсэн эсэх /бүрэн илэрхийлж чадсан эсэх/-ийг тодорхойлох зорилгоор сонгов.

¹ Монгол Улсын Их Хурлаас 2015 оны 5 дугаар сарын 29-ний өдөр баталсан.

² Хууль тогтоомжийн тухай хуулийн 12.1-д заасны дагуу Монгол Улсын Засгийн газраас 2016 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан.

“Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийг хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг хянах зорилгоор сонголоо.

"Хүлээн зөвшөөрөгдөх байдал" шалгуур үзүүлэлтийг хуулийн төслийн зохицуулалтыг холбогдох этгээдүүд хүлээн зөвшөөрөх эсэхийг тодорхойлох зорилгоор сонголоо.

“Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийг хуулийн төслийн дотооддоо болон бусад хуультай уялдах уялдаа холбоог сайжруулах үүднээс хуулийн төслийн зүйл, хэсэг, заалт өөр хоорондоо болон хүчин төгөлдөр үйлчилж байгаа бусад хуульд нийцсэн эсэх, давхардал, хийдэл, зөрчил байгаа эсэхийг тогтоох зорилгоор аргачлалд заасан асуултад хариулах замаар шалгахаар сонгов.

ХОЁР.ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ

"Зорилгод хүрэх байдал" шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Хуулийн төслийн зохицуулалт нь хуулийн төсөл боловсруулах болсон хэрэгцээ, шаардлагад нийцсэн эсэхийг шалгахын тулд хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хэрэгцээ, шаардлагыг хуулийн төсөлд хэрхэн тусгасныг тогтоох, эдгээр зохицуулалт нь үзэл баримтлалд тодорхойлсон хэрэгцээ, шаардлагад нийцсэн эсэхийг харьцуулан дүгнэхээр дараах байдлаар үнэлэх хэсгээ тогтоолоо.

Хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хэрэгцээ шаардлага	Хуулийн төслийн зохицуулалт
1.Шүүхийн ачааллыг өсгөж буй голлох хэрэг маргааны нэг нь зээлийн гэрээний маргаан байдаг бөгөөд шүүхийн бус журмаар өр барагдуулах үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг бий болгосноор шүүхийн ачааллыг бууруулах ач холбогдолтой. 2021 оны эхний хагас жилийн байдлаар иргэний хэргийн анхан шатны шийдвэрлэсэн нийт хэрэг, маргааны 50.1 хувийг Иргэний хуулийн 281-286 дугаар зүйл дэх зээлийн гэрээний маргаан, банк болон банк бус санхүүгийн байгууллагаас олгох зээлийн гэрээний маргаан дангаараа эзэлж байх бөгөөд үүнд Иргэний хуулийн 281-286 дугаар зүйл дэх зээлийн гэрээний маргаан 2550, банкны зээлийн маргаан 1517, банк бус санхүүгийн байгууллагын зээлийн маргаан 1469 буюу нийт 5536 зээлтэй холбоотой маргаан байна.	<u>-Хуулийн төслийн 6 дугаар зүйл.</u> 6.1.Шүүхээс өмнөх шатан дахь өр барагдуулах, өр төлбөртэй холбогдсон мэдээллийг цуглуулах, өрийн тохиролцоо хийх зэрэг үйлчилгээ үзүүлэх өр барагдуулах үйл ажиллагааг зээлдүүлэгчтэй байгуулсан гэрээний үндсэн дээр эрх бүхий хуулийн этгээд эрхэлнэ. 6.2.Өр барагдуулах үйл ажиллагааг хугацаа нь болсон төлөх үүрэг бүхий өр төлбөрт үндэслэн явуулна. 6.3.Өр барагдуулах үйл ажиллагаа эрхлэх этгээд болон зээлдүүлэгчийн хооронд байгуулах гэрээг бичгээр хийх бөгөөд дараах нөхцөлийг тусгана: 6.3.1.талуудын эрх, үүрэг; 6.3.2.талуудын хариуцлага;

Шүүхийн шийдвэрээс үзэхэд, зээлийн гэрээний өрийн үлдэгдэл болох 1,100,000 төгрөгийн нэхэмжлэлтэй хэрэг 3 шатны шүүхээр хянагдсан³ тохиолдол ч байна. Үүнээс гадна нэг шийдвэр гүйцэтгэгчид ногдох жишиг норматив 120-180 гүйцэтгэх хуудас байхаар тогтоосон⁴ хэдий ч бодит байдал дээр нэг шийдвэр гүйцэтгэгч үүнээс ч илүү хэмжээний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хариуцдаг. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад нийт гүйцэтгэвэл зохих баримт бичгийг шүүхийн шийдвэрийн төрлөөр нь ангилан харьцуулбал: Иргэний хэргийн шүүхийн шийдвэртэй баримт бичиг 74 хувь, эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэртэй баримт бичиг 18 хувь, захиргааны хэргийн шүүхийн шийдвэртэй баримт бичиг 1 хувь, зөрчлийн хэргийн шүүхийн шийдвэртэй баримт бичиг 2 хувь, бусад 5 хувийг тус тус бүрдүүлж байна. Иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэл нь 2020 оны эхний хагас жилийн байдлаар 23438 гүйцэтгэх баримт бичгийн 1.3 их наяд төгрөг биелүүлэхээс 7894 гүйцэтгэх баримт бичгийн 193.3 тэрбум төгрөгийг биелүүлж 15544 гүйцэтгэх баримт бичгийн 1.1 их наяд төгрөгийн үлдэгдэлтэй байна.⁵	6.3.3.өр төлбөртэй этгээдийн мэдээлэл; 6.3.4.өр төлбөрийн хэмжээ; 6.3.5.өрийн бүтэц /үндсэн төлбөр, хүү, торгууль гэх мэт/; 6.3.6.батлан даагчтай бол батлан даагчийн мэдээлэл; 6.3.7.барьцаатай бол барьцааны талаарх мэдээлэл; 6.3.8.гэрээний нөхөн төлбөрийн хэмжээ; 6.3.9.гэрээний хугацаа; 6.3.10.зээлийн төлөлт болон өр төлбөрийн хэмжээ өөрчлөгдөх тохиолдолд мэдэгдэх журам, нөхцөл; 6.3.11.гэрээний гүйцэтгэлийн талаар мэдээлэх журам; 6.3.12.гэрээг дуусгавар болгох журам, нөхцөл; 6.3.13.гэрээг хугацаанаас өмнө дуусгавар болгох нөхцөл, журам. <u>-Хуулийн төслийн 8 дугаар зүйл.</u> 8.1.Өр төлбөртэй этгээд зээлдүүдлэгчтэй байгуулсан гэрээний нөхцөлийг өөрчлөх зорилгоор өр барагдуулах албанаас мэдэгдэл хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор бичгээр хүсэлт гаргана. 8.2.Энэ хуулийн 8.1-д заасан хүсэлтэд зээлийн гэрээний нөхцөлийг өөрчлөх болсон шалтгааныг нотлох нөхцөл байдал, орлого, зарлагын хэмжээ, гэр бүлийн гишүүд, оршин суух хаяг, боловсрол, өмч хөрөнгө, зээлдүүлэгчийн шаардлагатай гэж үзсэн бусад мэдээлэл болон өр төлбөрийг төлөхөд түүний өмч, хөрөнгө хүрэлцэхгүй байгаа эсэх талаарх нөхцөлийг тодорхойлсон баримтыг хавсаргана. 8.3.Өр барагдуулах үйл ажиллагаа эрхлэх этгээд энэ хуулийн 8.1-д заасан
--	---

³Shuukh.mn, Улсын дээд шүүхийн хяналтын шатны иргэний хэргийн шүүх хуралдааны тогтоол 2019.06.13

⁴Хууль зүй, дотоод хэргийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2017 оны А247, А16, А303 дугаар хамтарсан тушаал.

⁵Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын статистик мэдээллээс.

	хүсэлтийг хүлээн авснаас хойш 10 өдрийн дотор уг хүсэлтийг зээлдүүлэгчид хүргүүлнэ. 8.4.Энэ хуулийн 8.3-т заасан хүсэлтийг зээлдүүлэгч хүлээн авснаас хойш 15 өдрийн дотор санал болгосон өөрчлөлтийг судлан үзэж, өр барагдуулах албанд дараах асуудлыг тусгасан мэдэгдлийг бичгээр хүргүүлнэ: 8.4.1.өр төлбөртэй этгээдийн санал болгосон нөхцөлөөр зээлийн гэрээний нөхцөлийг өөрчлөхийг зөвшөөрсөн тохиролцоо; 8.4.2.өөрийн зүгээс өөрчлөх санал, нөхцөл; 8.4.3.өр төлбөртэй этгээдийн санал болгосон нөхцөлөөр зээлийн гэрээний нөхцөлийг өөрчлөхөөс татгалзсан тухай мэдэгдэл, түүний үндэслэл. 8.5.Өр барагдуулах үйл ажиллагааны үед зээлдүүлэгчид дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно: 8.5.1.шүүхэд тухайн асуудлаар нэхэмжлэл гаргах; 8.5.2.аливаа хэлбэрийн зээл олгосны нөхөн төлбөр болон үндсэн зээл төлөлтийг хугацаа хожимдуулсны торгууль, алдангийг өр барагдуулах үйл ажиллагаа эрхлэгчид шилжүүлснээс хойшхи хугацаанд тооцож нэхэх. 8.6.Өрийн тохиролцоо хийхтэй холбоотой зээлдүүлэгч, эсхүл өр барагдуулах үйл ажиллагаа эрхлэгчийн үйлдэлд өр төлбөртэй этгээд холбогдох байгууллагад давж заалдах гомдол гаргах эрхтэй.
2.Монголбанкны мөнгөний нийлүүлэлт 2021 оны 7 дугаар сарын байдлаар 27 их наяд төгрөг байна. Мөн нийт олгосон зээлийн өрийн үлдэгдэл 19.5 их наяд төгрөг байгаагаас хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 1208.6 тэрбум төгрөг, чанаргүй зээл 1984.5 тэрбум төгрөг	16.1.Өр барагдуулах үйл ажиллагаа эрхлэгч дараах үүрэгтэй: 16.1.11.зээлжилтийн оноо өгөх эрх бүхий байгууллагатай мэдээлэл нийлүүлэх талаарх гэрээ байгуулах;

буюу өмнөх оныхоос 7.6 хувиар өссөн⁶ байна.⁷

Монгол Улсын Их Хурлаас Зээлийн хүүг бууруулах стратегийг Монгол Улсын Их Хурлын 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 21 дугаар тогтоолын хавсралтаар баталсан байна. Тус хавсралтын 2.2.1-д зээлийн эрсдэлийн зардлыг бууруулах, хэрэг, маргааныг зардал багатай шийдвэрлэх чиглэлээр эрх зүйн орчныг боловсронгуй болгохоор тусгасан.

Банкны салбарын чанаргүй зээл нь 2020 оны 5 дугаар сарын эцсийн байдлаар нийт зээлийн 11 гаруй хувийг эзэлж байгаа бөгөөд санхүүгийн зуучлалын үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын төлбөрийн чадварт шууд нөлөөлж зээл олголтыг бууруулж, зээлийн хүүг нэмэгдүүлэн улмаар санхүү, эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангахад сөрөг нөлөө үзүүлж байна. Чанаргүй зээл үүсэхэд банк түүний харилцагч, зээлдэгч нарын хооронд байгуулсан гэрээний шаардах эрхийг шүүхээр баталгаажуулж, үүргийн гүйцэтгэлийг албан журмаар хангах Монгол Улсын иргэний болон шүүхээс хэрэг хянан шийдвэрлэх хууль тогтоомжийн зохицуулалт нөлөөлж байгааг банк, санхүүгийн байгууллагын мэргэжилтэн, дотоодын судлаачдаас гадна Олон Улсын Валютын Сан, Европын сэргээн босголтын банк, Дэлхийн банк зэрэг байгууллагаас тогтоож, хууль тогтоомжийг боловсронгуй болгох зөвлөмж гаргасан байдаг.

Дэлхийн банкны “Doing business” жагсаалтад “гэрээний үүргийн хэрэгжилтийг хангах” буюу “enforcing contract” үзүүлэлт нь улсуудын бизнес эрхлэх орчны үнэлгээнд чухал үзүүлэлт

⁶ Монголбанкны мөнгөний нийлүүлэлт 2020 оны 3 дугаар сарын байдлаар 20.4 их наяд төгрөг байна. Мөн нийт олгосон зээлийн өрийн үлдэгдэл 17.1 их наяд төгрөг байгаагаас хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 1150.3 тэрбум төгрөг, чанаргүй зээл 1832.9 тэрбум төгрөг байна.

⁷ Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, 2021 оны 7 дугаар сар.

болдог билээ. Монгол Улс тус үзүүлэлтээр 75 дугаар байранд жагсаж байна.⁸ Тухайлбал, Дэлхийн банкнаас жил бүр гаргадаг “Бизнес эрхлэх орчин” 2020 тайлан, Олон Улсын Валютын Сангийн зөвлөмжид гэрээний маргааныг шүүхээр шийдвэрлэх удаашралтай, баримт бичгийн бүрдлийг цахимаар хангах боломжгүй, төлбөрийн чадваргүйдлийн зохицуулалт дутмаг, барьцааны шаардлагыг баталгаажуулаагүй, <u>шүүхийн бус журмаар маргаан шийдвэрлэх эрх зүйн зохицуулалт байхгүй</u> байна гэж дүгнэсэн байдаг.⁹ Зээлийн хүү нь зээлийн чанаргүйдэлтэй холбоотой эрсдэлийн сангийн зардал, чанаргүй авлагыг барагдуулахтай холбоотой хууль, шүүхийн процесс, түүнтэй холбоотой гарах зардал, ашигт ажиллагааны норм зэргээс хамаарч байна.¹⁰ Чанаргүй зээлийг шүүхийн журмаар шийдвэрлүүлэхэд дунджаар 6.2 жил шаардагдаж байгаа бол шүүхийн бус журмаар үүнээс хоёр дахин бага хугацаа буюу 3.4 жил зарцуулагджээ. Мөн шүүхийн журмаар барагдуулсан активт зарцуулсан хамгийн бага хугацаа нь 134 хоног, хамгийн их хугацаа нь 6058 хоног буюу 16.6 жил байна. (Үүнд 3 шатны шүүх, ШШПГ-аас гүйцэтгэсэн хугацааг оруулаад тооцсон.)¹¹	
3.Зээлдүүлэгч нь хэт өндөр хүүтэй зээлийн гэрээнээс үүдэлтэй маргаанаа шүүхээр шийдвэрлүүлэх хүсэлгүй байдаг тул зээлээ буцаан шаардахдаа дарамтлах, нэр хүндийг гутаах, орон байрны халдашгүй байдалд халдах зэрэг хууль бус	<u>-Хуулийн төслийн 7 дугаар зүйл</u> 7.1.Зээлдүүлэгчтэй байгуулсан гэрээнд заасан үүргийн хүрээнд өр барагдуулах үйл ажиллагаа эрхлэх этгээд нь өр төлбөртэй этгээд болон түүний төлөөлөгч, гуравдагч этгээдтэй дараах байдлаар харилцана:

⁸ <https://www.doingbusiness.org/en/rankings>

⁹ Төрөөс мөнгөний бодлогын талаар 2021 онд баримтлах үндсэн чиглэлийн төсөл, Монголбанк, 2020 он, 12 дугаар тал.

¹⁰ Төрөөс мөнгөний бодлогын талаар 2021 онд баримтлах үндсэн чиглэлийн төсөл, Монголбанк, 2020 он, 17 дугаар тал.

¹¹ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар

арга хэрэгслүүдийг ашигладаг байна.¹² Өдрийн зээлээс болж Хархорин зах дээр наймаа эрхэлдэг 20 настай бүсгүй амиа хорлосон¹³ гэх мэдээлэл ч байна. Түүнчлэн иргэд хоорондын бусад зээлийн гэрээнд өр нэхэхдээ айлгах, сүрдүүлэх, дарамтлах, шөнийн цагаар залгах, цахим орчинд нэр хүндэд нь халдах зэргээр зохисгүй арга хэмжээ авч, үүнд тавих хяналт, хариуцлагын тогтолцоо байхгүй байгаа нь зээлдэгчийн эрхэд зүй бусаар халдахад хүргэж байна. Эндээс харахад, зээлдүүлэгч болон түүний томилсон өр барагдуулах алба аль аль нь зээлдэгчээс өрийг буцаан шаардахдаа зүй зохистой харьцах стандартыг тогтоох шаардлага байна.	7.1.1.утсаар; 7.1.2.биечлэн уулзалт; 7.1.3.иргэн бол оршин суух хаягаар, хуулийн этгээд бол хуулийн этгээдийн хаягаар бичгээр; 7.1.4.мессеж, дуут мессежээр; 7.1.5.интернетээр. 7.2.Өр барагдуулах үйл ажиллагаа эрхлэх этгээд өр төлбөртэй этгээд, түүний төлөөлөгч, эсхүл гуравдагч этгээдтэй харилцахдаа дараах журмыг баримтална: 7.2.1.ажлын өдөр 08.00 цагаас 21.00 цаг хүртэлх хугацаанд харилцах; 7.2.2.өр барагдуулах албаны санаачилгаар долоо хоногт гурваас дээшгүй удаа болон ажлын нэг өдөрт нэгээс дээшгүй удаа биечлэн уулзах; 7.2.3.өр барагдуулах албаны санаачилгаар ажлын өдөр 08.00 цагаас 21.00 цаг хүртэлх хугацаанд гурваас дээшгүй удаа утсаар холбогдох; 7.2.4.өр төлбөртэй этгээдийн хүсэлтээр өр төлбөртэй холбогдох баримт бичиг, мэдээллээр хангах; 7.2.5.талуудаас хүлээн авсан мэдээллийн аюулгүй байдлыг хангах. 7.3.Өр барагдуулах үйл ажиллагаа эрхлэх этгээд өр төлбөртэй этгээд, түүний төлөөлөгч, гуравдагч этгээдтэй харилцахдаа дараах хууль бус үйлдэл үзүүлэхийг хориглоно: 7.3.1.нэр хүндэд нь халдах; 7.3.2.амь нас, эрүүл мэнд, өмч хөрөнгө болон бусад асуудлаар заналхийлэх байдлаар эрх, эрх чөлөөг нь зөрчсөн хууль бус үйлдэл гаргах;
--	--

¹²<http://dardas.mn/news/view/1254> Сэтгүүлч Ц.Чандмань-Эрдэнийн жижиглэнгийн худалдаа эрхлэгчидтэй хийсэн ярилцлагаас.

¹³ Мөн тэнд.

	7.3.3.зээлийн гэрээний үүргээ биелүүлэхийг албадах, сүрдүүлэх, хуурамч бичиг баримт үйлдэх; 7.3.4.зээлдүүлэгчээс хүлээн авсан мэдээллээс худалдааны болон хуульд заасан бусад нууцад хамааруулсан мэдээллийг ил болгох; 7.3.5.хамааралгүй этгээдэд болон олон нийтэд өр төлбөрийн талаар мэдээлэх.
4.Монгол Улсад банк¹⁴, банк бус санхүүгийн байгууллага¹⁵, хадгаламж зээлийн хоршоо¹⁶ гэсэн зээлийн үйл ажиллагаа явуулж буй байгууллагууд эрх бүхий байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлийн¹⁷ үндсэн дээр үйл ажиллагаа явуулж байна. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3.4 дэх заалтад “банкнаас бусад этгээд хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх” тохиолдолд тусгай зөвшөөрөл авсан байх ёстой талаар заасан хэдий ч тус зохицуулалт дан ганц “хадгаламж зээлийн хоршоодод олгох тусгай зөвшөөрөл” мэтээр ойлгож ирсэн нь иргэд, эсхүл зээлийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлгүй компаниуд байнга, ашгийн төлөө зээлийн үйл ажиллагаа эрхлэх нөхцөл байдлыг үүсгээд байна. 2021 оны эхний хагас жилийн байдлаар иргэний хэргийн анхан шатны шийдвэрлэсэн нийт хэрэг, маргааны 50.1 хувийг Иргэний хуулийн 281-286 дугаар зүйл дэх зээлийн гэрээний маргаан, банк болон банк бус санхүүгийн байгууллагаас олгох зээлийн гэрээний маргаан дангаараа эзэлж байх бөгөөд үүнд Иргэний хуулийн 281-286 дугаар зүйл дэх зээлийн гэрээний маргаан 2550 нь байна. Ийнхүү тусгай	<u>-Хуулийн төслийн 4 дүгээр зүйл</u> 4.1.3.“зээлдүүлэгч” гэж банк, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо, түүнчлэн мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгч этгээдийг. <u>-Хуулийн төслийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг</u> 6.1.Шүүхээс өмнөх шатан дахь өр барагдуулах, өр төлбөртэй холбогдсон мэдээллийг цуглуулах, өрийн тохиролцоо хийх зэрэг үйлчилгээ үзүүлэх өр барагдуулах үйл ажиллагааг зээлдүүлэгчтэй байгуулсан гэрээний үндсэн дээр эрх бүхий хуулийн этгээд эрхэлнэ.

¹⁴Банкны тухай хууль

¹⁵Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль

¹⁶Хадгаламж, зээлийн хоршооны тухай хууль

¹⁷Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль

зөвшөөрөлтэй зээлийн үйл ажиллагаа эрхлэгчдээс гадна тусгай зөвшөөрөлгүй зээлийн үйл ажиллагаа эрхлэгч нар ямар ч ялгаагүй зээлийн үйл ажиллагаа эрхэлж, шүүхээс ялгаж авч үзэлгүй хэрэг маргааныг шийдвэрлэж, шүүхийн ачаалал нэмэгддэг байдлыг бууруулахад өр барагдуулах албаны эрх зүйн зохицуулалт тодорхой түлхэц болно.	
--	--

"Ойлгомжтой байдал" гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг шалгах тул хуулийн төслийг бүхэлд нь шалгахаар сонгов.

"Хүлээн зөвшөөрөгдөх байдал" гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Хуулийн төсөлд шинээр бий болж байгаа зохицуулалтыг иргэн, хуулийн этгээд хүлээн зөвшөөрч хэрэгжүүлэх эсэхийг хэрэгжүүлэх эсэхийг шалган тогтоох үүднээс сонгон авлаа.

-Хуулийн төслийн 7 дугаар зүйл

7 дугаар зүйл.Өр барагдуулах үйл ажиллагаа эрхлэх журам

7.2.Өр барагдуулах үйл ажиллагаа эрхлэх этгээд өр төлбөртэй этгээд, түүний төлөөлөгч, эсхүл гуравдагч этгээдтэй харилцахдаа дараах журмыг баримтална:

7.2.1.ажлын өдөр 08.00 цагаас 21.00 цаг хүртэлх хугацаанд харилцах;

7.2.2.өр барагдуулах албаны санаачилгаар долоо хоногт гурваас дээшгүй удаа болон ажлын нэг өдөрт нэгээс дээшгүй удаа биечлэн уулзах;

7.2.3.өр барагдуулах албаны санаачилгаар ажлын өдөр 08.00 цагаас 21.00 цаг хүртэлх хугацаанд гурваас дээшгүй удаа утсаар холбогдох;

7.2.4.өр төлбөртэй этгээдийн хүсэлтээр өр төлбөртэй холбогдох баримт бичиг, мэдээллээр хангах;

7.2.5.талуудаас хүлээн авсан мэдээллийн аюулгүй байдлыг хангах.

7.3.Өр барагдуулах үйл ажиллагаа эрхлэх этгээд өр төлбөртэй этгээд, түүний төлөөлөгч, гуравдагч этгээдтэй харилцахдаа дараах хууль бус үйлдэл үзүүлэхийг хориглоно:

7.3.1.нэр хүндэд нь халдах;

7.3.2.амь нас, эрүүл мэнд, өмч хөрөнгө болон бусад асуудлаар заналхийлэх байдлаар эрх, эрх чөлөөг нь зөрчсөн хууль бус үйлдэл гаргах;

7.3.3.зээлийн гэрээний үүргээ биелүүлэхийг албадах, сүрдүүлэх, хуурамч бичиг баримт үйлдэх;

7.3.4.зээлдүүлэгчээс хүлээн авсан мэдээллээс худалдааны болон хуульд заасан бусад нууцад хамааруулсан мэдээллийг ил болгох;

7.3.5.хамааралгүй этгээдэд болон олон нийтэд өр төлбөрийн талаар мэдээлэх.

"Харилцан уялдаа" гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалт өөр хоорондоо болон хуулийн төслийг бусад хуультай нийцсэн, уялдсан эсэхийг шалгах тул бүхэлд нь шалгахаар сонголоо.

ГУРАВ.ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

Аргачлалд заасны дагуу хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлт, үр нөлөөг үнэлэх хэсгийг дээрх 2 үе шатанд тус тус тогтоосны дагуу тэдгээрт тохирох шалгах хэрэгслийг дараах байдлаар тодорхойллоо:

Д/д	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Тохирох шалгах хэрэгсэл
1.	Зорилгод хүрэх байдал	Энэхүү үнэлгээний тайлангийн Хоёр дахь хэсэг буюу Зорилгод хүрэх байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлэхээр сонгосон зохицуулалтууд. /Үнэлгээний тайлангийн 4-11 дүгээр хуудас/	Зорилгод дүн шинжилгээ хийх: Хуулийн төслийн зохицуулалт нь төслийн үзэл баримтлалд дурдсан хэрэгцээ, шаардлагад нийцсэн эсэхэд дүн шинжилгээ хийнэ.
2.	Ойлгомжтой байдал	Хуулийн төсөл бүхэлдээ /Хуулийн төсөл 5 бүлэг, 20 зүйлтэй/	Ойлгомжтой байдлыг шалгах: Хууль тогтоомжийн тухай хууль, "Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал"-ыг баримталсан эсэхийг шалгана.
3.	Хүлээн зөвшөөрөгдөх байдал	Хуулийн төслийн 7 дугаар зүйлийн 7.2, 7.3 дахь хэсэг	Хүлээн зөвшөөрөгдөх байдлын судалгаа хийх: Иргэд, олон нийтээс цахимаар санал асуулга авах, өдрийн зээл авдаг зээлдэгч нараас анкетаар санал авах, бодитоор байгуулсан зээлийн гэрээний нөхцөлийг шалгаж дүгнэлт хийх замаар шалгана.
4.	Харилцан уялдаа	Хуулийн төсөл бүхэлдээ	Хуулийн төслийн уялдаа холбоог шалгах:

		/Хуулийн төсөл 5 бүлэг, 20 зүйлтэй/	Хуулийн төслийн уялдаа холбоог аргачлалын 4.10-т заасан асуултад хариулах замаар шалгана.
--	--	-------------------------------------	---

Дээрх урьдчилан сонгож авсан шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу хуулийн төсөлд үр нөлөөний үнэлгээг дараах байдлаар хийв.

3.1.“Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалт нь хуулийн төсөл боловсруулах болсон хэрэгцээ, шаардлагад нийцсэн эсэхийг шалгахын тулд хуулийн төслийн үзэл баримтлалд¹⁸ тусгасан хэрэгцээ, шаардлагыг хуулийн төсөлд хэрхэн тусгасныг тогтоох, эдгээр зохицуулалт нь үзэл баримтлалд тодорхойлсон хэрэгцээ, шаардлагад нийцэж байгаа эсэхийг харьцуулан дүн шинжилгээ хийлээ.

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт Баялаг бүтээгч хувийн хэвшлийг дэмжсэн Арилжааны багц хууль боловсруулахаар, түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл"-ийн 73 дугаарт Шүүхийн бус журмаар өр барагдуулах үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн төслийг Хууль зүй, дотоод хэргийн яамнаас боловсруулж, 2021 онд Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр, "Монгол Улсын Их Хурлын 2021 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай" Монгол Улсын Их Хурлын 2021 оны 75 дугаар тогтоолын 68-д "Шүүхийн бус журмаар өр барагдуулах үйл ажиллагааны тухай хуулийн төсөл"-ийг тусгасан.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 2020 оны “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2021 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” 32 дугаар тогтоолын 3-д “санхүүгийн гэрээ, хэлцэлд оролцогч талуудын үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлж, тэдгээрийн хооронд үүссэн маргааныг шүүхээс богино хугацаанд үр дүнтэй шийдвэрлэх, барьцаалагчийн шаардах эрхийг хангуулах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд төлбөр авагчийн эрхийг хамгаалах чиглэлээр хууль, эрх зүйн орчныг сайжруулах” гэж, мөн оны “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 24 дүгээр тогтоолын хавсралтын 3.1.8-д Банк, санхүүгийн систем дэх чанаргүй зээлийг шуурхай, зардал багатай шийдвэрлэх хууль, эрх зүйн шинэчлэл хийж, санхүү, эдийн засгийн хүндрэлийг богино хугацаанд даван туулж, эдийн засгийн тогтвортой, хүртээмжтэй өсөлтийг хангах бодлого хэрэгжүүлэхээр заасан.

Дээрх бодлогын баримт бичигт тусгасан зорилго, зорилтыг хэрэгжүүлэх үүднээс Шүүхийн бус журмаар өр барагдуулах үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн төслийг боловсруулах үндэслэл, хэрэгцээ шаардлага гарсан байх бөгөөд хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хэрэгцээ, шаардлагыг хуулийн төсөлд хэрхэн тусгасан, түүнчлэн хуулийн төсөлд бүрэн дүүрэн, хангалттай тусгаж чадсан эсэхэд дараах байдлаар үнэлэлт, дүгнэлт хийлээ. Үүнд:

¹⁸Хууль зүй, дотоод хэргийн сайдын баталсан Шүүхийн бус журмаар өр барагдуулах үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал.

1.Шүүхийн болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ачааллыг бууруулах, эрхээ хамгаалуулах альтернатив, түргэн шуурхай механизмыг бий болгох эрх зүйн зохицуулалтыг хуулийн төслөөр бий болгох гэсэн хэрэгцээ, шаардлагын хүрээнд:

-Энэ хэрэгцээ, шаардлагын хүрээнд хуулийн төсөлд шүүхийн бус журмаар өр барагдуулах үйл ажиллагаа эрхлэгчийн үйл ажиллагааг бүртгэх, бүртгүүлэхэд тавигдах шаардлага, бүртгэх, хянах байгууллагыг тодорхойлж, өр барагдуулах ажиллагаанд зөвхөн зээлдүүлэгч талын эрхийг хангасан бус, санхүүгийн хэрэглэгч болох зээлдэгчийн эрхийг хангасан тэнцвэртэй үйл ажиллагаа явуулах талаар тусгасан нь үзэл баримтлалын дээрх хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

-Тухайлбал, хуулийн төслийн 5 дугаар зүйлийн дагуу үйл ажиллагаа эрхлэх этгээдийг тодорхойлж, 5 дугаар зүйлд мөн үйл ажиллагаа эрхлэгчийн удирдлагыг хэрэгжүүлэх болон нийт хувьцааны арав болон түүнээс дээш хувийг эзэмших этгээдэд тавигдах хязгаарлалтыг тогтоож, 6 дугаар зүйлээр өр барагдуулах үйл ажиллагаа эрхлэх, гэрээнд тусгах асуудал, 8 дугаар зүйлээр өрийн тохиролцоо хийх журмыг, 9 дүгээр зүйлд үйл ажиллагаа эрхлэгчээр бүртгүүлэх өргөдөл гаргах, бүртгүүлэхэд бүрдүүлэх баримт бичиг, 10 дугаар зүйлд бүртгүүлэхэд тавигдах шаардлага, бүртгэхээс татгалзах үндэслэлийг, 14 дүгээр зүйлд үйл ажиллагаа эрхлэгч, түүний удирдлага, ажилтанд тавигдах шаардлага, 16-17 дугаар зүйлд өр барагдуулах алба, өр төлбөртэй этгээдийн эрх үүрэг, 18 дугаар зүйлээр үйл ажиллагаанд хяналт тавих, арга хэмжээ авах асуудлыг зохицуулсан байна.

Хуулийн төслийн 8 дугаар зүйлд өр төлбөртэй этгээдэд мэдэгдэх хугацаа, өр барагдуулах алба зээлдүүлэгчид хүргүүлэх, зээлдүүлэгч хариу өгөх хугацааг хүндэтгэн үзэх шалтгаанаар сунгах нөхцөл, хугацаа дууссан бол хэрхэх, хэрэв тус ажиллагаа амжилтгүй болвол, эсхүл зээлдүүлэгчийн хүсэлтээр өр барагдуулах үйл ажиллагааг зогсоож шүүхэд хандаж болох талаарх зохицуулалтыг нэмэх шаардлагатай байна. Учир нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14-т зааснаар Монгол Улсын иргэн Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах үндсэн эрхтэй бөгөөд хуулийн төслийн үзэл баримтлалд тусгаснаар шүүхийн бус журмаар өр барагдуулах үйл ажиллагаа нь шүүхэд хандахаас өмнө заавал гүйцэтгэх үе шат бус, зээлдүүлэгчийн хүсэлтээр явагдах, альтернатив нэг шийдэл тул зээлдүүлэгч хүсвэл уг үйл ажиллагааг зогсоох, шүүхэд хандах үндсэн эрх нь нээлттэй болно.

2.Зээлийн хүүг бууруулах, зээлийн эргэн төлөлтийг түргэн шуурхай болгох, чанаргүй зээлийг бууруулах гэсэн хэрэгцээ, шаардлагын хүрээнд:

-Энэ хэрэгцээ, шаардлагыг хангах үүднээс сонгож авсан хуулийн төслийн 16 дугаар зүйлийн 16.1.11 дэх заалтаар өр барагдуулах алба нь зээлжилтийн оноо өгөх эрх бүхий байгууллагатай мэдээлэл нийлүүлэх талаарх гэрээ байгуулах үүрэгтэй байна.

Энэхүү зохицуулалтаар өр барагдуулах үйл ажиллагаа эрхлэгч зээлийн мэдээллийн санд мэдээлэл нийлүүлэх, зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэгч нь зээлдэгчийн зээлжих чадвар, зэрэглэлийг тогтоохоор байгаа нь зээлдэгч зээлээ төлөх хөшүүрэг болно гэж үзэж байна. Харин хуулийн төсөлд "зээлжилтийн оноо өгөх эрх бүхий байгууллагатай мэдээлэл нийлүүлэх талаарх гэрээ байгуулах" гэж томъёолсныг зээлийн мэдээллийн санд мэдээлэл

нийлүүлэх гэж өөрчлөх нь зүйтэй байна. Түүнчлэн дагах хуулийн төсөл боловсруулахдаа Зээлийн мэдээллийн тухай хуульд заасан мэдээлэл нийлүүлэгч гэх тодорхойлолтод өр барагдуулах албыг нэмэх шаардлагатай.

3.Зээлдүүлэгч зээлээ нэхэхдээ зээлдэгчийн эрх ашгийг ноцтой зөрчсөөр байгаа асуудлыг шийдвэрлэх хэрэгцээ шаардлагын хүрээнд:

"Энэ хуулийн зорилт нь шүүхийн бус журмаар өр барагдуулах үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийг бүртгэх, үйл ажиллагаанд нь хяналт тавих, тэдгээрээс явуулах үйл ажиллагаан дахь хэрэглэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино." гэж хуулийн төслийн 1 дүгээр зүйл дэх хуулийн зорилтод тодорхойлжээ.

Харин үзэл баримтлалд зааснаар "зээлдүүлэгч нь хэт өндөр хүүтэй зээлийн гэрээнээс үүдэлтэй маргаанаа шүүхээр шийдвэрлүүлэх хүсэлгүй байдаг тул зээлээ буцаан шаардахдаа дарамтлах, нэр хүндийг гутаах, орон байрны халдашгүй байдалд халдах, цахим орчинд нэр хүндэд нь халдах зэрэг хууль бус арга хэрэгслүүдийг ашигладаг нь үүнд тавих хяналт, хариуцлагын тогтолцоо байхгүй байгаа нь зээлдэгчийн эрхэд зүй бусаар халдахад хүргэж байна." гэж хуулийн төсөл боловсруулах нэгэн практик хэрэгцээ, шаардлагыг тодорхойлсон байна.

Тэгвэл хуулийн төслийн зорилтод "шүүхийн бус журмаар өр барагдуулах үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдээс явуулах үйл ажиллагаан дахь хэрэглэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулах" гэж зөвхөн шүүхийн бус журмаар өр барагдуулах үйл ажиллагаа эрхлэх этгээдээс явуулах үйл ажиллагаанд зээлдэгчийн эрх ашгийг зөрчигдөхөөс хамгаалах байдлаар тусгасан байгааг *бүхий л зээлдүүлэгч, түүний төлөөлөгч, банк, банк бус санхүүгийн байгууллагын хувьд тэдгээрийн өр барагдуулах дотоод нэгжээс зээлдэгчтэй харьцахдаа энэ хуулийн төсөлд заасан зээлдэгчтэй харьцах стандартыг дагаж мөрдвөл зээлдэгчийн бусад эрх зөрчигдөхөөс хамгаалах* тул хуулийн төслийн зорилт хэсэгт "... зээлдүүлэгч, түүний төлөөлөгч болон шүүхийн бус журмаар өр барагдуулах үйл ажиллагаа эрхлэгчээс зээлдэгчтэй харьцах харилцаанд зээлдэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах" гэж тодорхойлж, хамрах хүрээг өргөжүүлснээр үзэл баримтлал дахь үүнтэй холбогдох хэрэгцээ, шаардлагыг бүрэн хангана гэж үзэж байна.

Хуулийн төслөөс харвал шүүхийн бус журмаар өр барагдуулах үйл ажиллагааны объект нь хэрэглээний зээл, эсхүл бизнесийн зээл байж болох эсэх нь тодорхойгүй байх бөгөөд энэ хүрээнд гадаад улсын туршлагаас үзвэл, Солонгос улсын хувьд¹⁹ шүүхээс өмнөх шатан дахь зээлийг нэхэх харилцаанд зээлдэгчтэй харьцах стандарт тогтоосон нь бизнесийн зээлд хамаардаггүй, зөвхөн иргэний хэрэглээний зээлд, Америкийн нэгдсэн улсын хувьд²⁰ бизнесийн зээлд хамаардаггүй, зөвхөн иргэний хэрэглээний зээлд хамааралтай байна. Харин Казакстан улсын хувьд²¹ хэрэглээний болон бизнесийн зээл аль аль нь хамаарч болохоор байна. Хэрэглэгчийн эрхийн асуудал нь *хуулийн этгээд зээлдэгч байх*

¹⁹ https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?lang=ENG&hseq=32731

²⁰ <https://www.ftc.gov/enforcement/rules/rulemaking-regulatory-reform-proceedings/fair-debt-collection-practices-act-text>

²¹ <https://www.mondaq.com/financial-services/625154/state-regulation-of-debt-collection-activities-in-kazakhstan>

тохиолдолд, эсхүл бизнесийн зээлд хамаарах эсэхийг дахин нягтлан "өр төлбөртэй этгээд" гэдэгт хэнийг оруулахыг томъёолох шаардлагатай байна.

Батлан даагч, баталгаа гаргагч, хамтран зээлдэгч болон өр төлбөр бүхий этгээдийн хамаарал бүхий этгээдтэй хэрхэн харилцах, ямар мэдээлэл өгөх талаар нэмж тусгах шаардлагатай байна. Тухайлбал, Солонгос улсын холбогдох хуулийн 2 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт "хамааралтай этгээд" гэснийг өр төлбөртэй этгээдтэй хамт амьдардаг, эсхүл хамт ажилладаг этгээд байхаар зааж, мөн хуулийн 8-3 дугаар зүйлд өр төлбөр нэхэж буй этгээдийн хамааралтай этгээдтэй хэрхэн харилцах журмыг тусгажээ. Үүнд, өр төлбөртэй этгээдийн хаана байгаа, холбогдох мэдээлэл, хаанаас олж болох талаар асуухаас бусад тохиолдолд хамааралтай этгээдэд өр төлбөрийн талаар мэдээлэл аливаа хэлбэрээр өгч, эсхүл гэрт нь очиж болохгүй. Хэрэв өр төлбөртэй этгээд нь хамааралтай этгээдтэй уулзах, захидал илгээх бол өөрийн нэр, холбогдох мэдээлэл, уулзах зорилго, зээлдүүлэгчийн нэр, зорилгыг мэдэгдэх ёстой талаар тусгажээ.

Дээрх хэрэгцээ, шаардлагыг хангах зохицуулалтыг хуулийн төслийн 7 дугаар зүйлд тусгасанд дүн шинжилгээ хийвэл өр барагдуулах үйл ажиллагаа эрхлэгчээс зээлдэгчтэй харилцахдаа хориглох үйлдэл, эс үйлдлийг тусгасан нь үзэл баримтлал дахь зээлдэгчийн эрх ашгийг ноцтой зөрчих явдлыг шийдвэрлэх хэрэгцээ, шаардлагыг хангахаар байна гэж үзэв.

Гэхдээ хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалтад өр барагдуулах үйл ажиллагаа гэснийг тодорхойлсон байх бөгөөд мөн төслийн 5 болон 9 дүгээр зүйлд зааснаар өр барагдуулах үйл ажиллагаа эрхлэх этгээд нь Санхүүгийн зохицуулах хороонд бүртгүүлэхээр байна. Харин өр барагдуулах бүртгэлд бүртгэгдсэн этгээдээс гадна банкны дэргэдэх өр барагдуулах алба ч мөн адил зээлдэгчтэй харьцахдаа энэ хуулийн төсөлд тусгагдсан хязгаарлалтыг дагаж мөрдөх нь зүйтэй юм. Мөн зээлдүүлэгч нь өөрөө хувиараа, эсхүл хуульч, төлөөлөгчөөрөө дамжуулан зээлдэгчээс зээлээ нэхэхдээ ч гэсэн энэхүү стандартыг дагаж мөрдсөнөөр зээлдэгчийн эрх ноцтойгоор зөрчигдөхөөс бүрэн хамгаалахаар байх тул өр төлбөр барагдуулах этгээд гэх нэр томъёог өргөн хүрээнд авч үзэх эсэхийг нягтлах нь зүйтэй.

Энэ талаарх гадаад улсын туршлагаас судалж үзвэл, Солонгос, Америкийн нэгдсэн улсын хуульд өр төлбөр цуглуулагч гэдэгт зээлийн төлбөрийг нэхэх зээлдүүлэгч, түүний өмнөөс нэхэх төлөөлөгч гээд зээлдэгчтэй харьцах бүхий л этгээдийг хамааруулж, өргөн хүрээнд тодорхойлсон байна. Харин Казакстан улсын хувьд²², зөвхөн өр барагдуулах албыг өр төлбөр цуглуулагч гэж тодорхойлжээ.

Түүнчлэн хуулийн төслийн 7 дугаар зүйл дэх хязгаарлалтыг зөрчсөн тохиолдолд хэрхэн хариуцлага хүлээх талаар дагах хуулийн төсөлд оновчтой тусгахыг анхаарах шаардлагатай.

Мөн өр төлбөртэй этгээд өөрөө хүсвэл түүнтэй холбогдохгүй байх буюу түүний томилсон хуульч, төлөөлөгчтэй нь харилцах зохицуулалтыг нэмж тусгах шаардлагатай байна. Энэ талаар Солонгос Улсын хуулийн 8-2 дугаар зүйлд заажээ.²³

4.Иргэд, эсхүл зээлийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлгүй компаниуд байнга, ашигийн төлөө зээлийн үйл ажиллагаа эрхлэх асуудлыг өр барагдуулах үйл ажиллагааны

²²<https://www.mondaq.com/financial-services/625154/state-regulation-of-debt-collection-activities-in-kazakhstan>

²³https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?lang=ENG&hseq=32731

тухай хуулиар бууруулах, тэд өр барагдуулах үйл ажиллагаанд оролцох боломжгүй байхаар шийдвэрлэх хэрэгцээ, шаардлагын тухайд:

Энэхүү хэрэгцээ, шаардлагын хүрээнд сонгож авсан хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалтад “зээлдүүлэгч” гэж банк, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо, түүнчлэн мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгч этгээдийг.” гэж, мөн төслийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт “Шүүхээс өмнөх шатан дахь өр барагдуулах, өр төлбөртэй холбогдсон мэдээллийг цуглуулах, өрийн тохиролцоо хийх зэрэг үйлчилгээ үзүүлэх өр барагдуулах үйл ажиллагааг зээлдүүлэгчтэй байгуулсан гэрээний үндсэн дээр эрх бүхий хуулийн этгээд эрхэлнэ.” гэж тус тус заасанд дүн шинжилгээ хийхэд уг хэсэг нь үзэл баримтлалд тусгагдсан хэрэгцээ, шаардлагыг хангаж байна.

Учир нь өр барагдуулах эрх бүхий этгээд нь зөвхөн банк, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо, түүнчлэн мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгч этгээдтэй гэрээ байгуулахаар ойлгогдож, байнга, ашгийн төлөө мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхэлдэггүй, бүртгэлгүй этгээд өр барагдуулах үйл ажиллагаа эрхлэгчтэй гэрээ байгуулахгүй болж, улмаар тусгай зөвшөөрөлгүйгээр байнга, ашгийн төлөө зээлийн үйл ажиллагаа эрхлэгчийг хумих, цаашлаад санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах ач холбогдолтой байна.

Мөн хуулийн төсөлд шүүхийн өмнөх шатан дахь өр барагдуулах алба нь банк, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршооноос бусад мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгчийн бүртгэлд бүртгүүлээгүй байнга, ашгийн төлөө зээлийн үйл ажиллагаа эрхлэгч зээлдүүлэгчид үйлчилгээ үзүүлэхгүй талаар зохицуулалт тусгаж, зөрчвөл холбогдох хариуцлага тооцохыг дагах хуулийн төсөлд хуульчлах боломжтой. Харин Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгчийн бүртгэлд бүртгүүлээгүй байнга, ашгийн төлөө зээлийн үйл ажиллагаа эрхлэгч зээлдүүлэгч нар зээлээ эргэн нэхэхдээ зээлдэгчтэй харьцах стандартыг бол дагаж мөрдөх нь зүйтэй гэж үзэж байна.

3.2.“Ойлгомжтой байдлыг шалгах” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

Хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хууль, "Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал"-ыг баримталсан эсэхийг шалгасан байдал:

Хуулийн төслийг бүхэлд нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хууль тогтоомжийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагад нийцүүлэн боловсруулсан эсэхийг аргачлалын дагуу дараах асуултад хариулт өгөх байдлаар шалгалаа.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан Хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага	
Хууль тогтоомжийн тухай хуулийн зохицуулалт	Хуулийн төслийн зохицуулалтад үнэлгээ хийсэн байдал
29.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд	Шаардлага хангасан.

нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх;	
29.1.2.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх;	Зарим зохицуулалт дутуу байна. Үүнд: -Өр төлбөртэй этгээдийн хамаарал бүхий этгээдтэй харьцах стандартыг нэмэх; -Бүх зээлдүүлэгч өөрөө өр төлбөрөө нэхэхдээ, эсхүл төлөөлөгч болон өр барагдуулах албаар дамжуулан нэхвэл өр нэхэж буй төлөөлөгч, эсхүл өр барагдуулах алба нь хуулийн төсөлд тусгагдсан зээлдэгчтэй харьцах стандартыг дагаж мөрдөх эсэх талаар дахин нягталж үзэх; -Бүртгүүлэхэд бүрдүүлэх баримт бичиг, бүртгэлийн гэрчилгээг ямар хугацаатай олгох, сунгах, түдгэлзүүлэх, сануулах, хүчингүй болгох нөхцөлийг ялгамжтай тусгах; -Банк, банк бус санхүүгийн байгууллагын дотоод бүтцийн өр барагдуулах алба болон зээлдүүлэгчийн томилсон хуульчид энэ хуульд заасан зээлдэгч, түүний хамааралтай этгээдтэй харьцах стандартаас бусад зохицуулалт үйлчлэхгүй талаар тусгах боломжтой эсэхийг нягтлах; -Хуулийн төслийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсэгт заасан шаардлага нь өр барагдуулах албаны эрх бүхий албан тушаалтанд хамаарч байх тул эдгээр шаардлагаас аль нь өр барагдуулах албаны ажилтанд хамаарахыг мөн зүйлийн 14.3 дахь хэсэгт эшлэх.
29.1.3.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх;	Шаардлага хангасан.
29.1.4.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгахгүй байх;	Дагах хуулийн төсөл боловсруулагдаагүй байх тул холбогдох хуулийн төслийг боловсруулах.
29.1.5.зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх;	Хуулийн төслийн 7 дугаар зүйлийн гарчигийг Зээлдэгч, түүний хамаарал бүхий этгээдтэй харилцах журам гэж өөрчлөх,

	учир нь дан ганц өр барагдуулах албаны үйл ажиллагааг өр барагдуулах үйл ажиллагаа гэж тодорхойлсон байх бөгөөд хуулийн төслийн 7 дугаар зүйл нь өр барагдуулах албанд дан ганц хамаарах бус бусад зээлдүүлэгч, тэдгээрийн төлөөлөгч, эсхүл хуульч гээд өр төлбөрөө нэхэх бүхий л субъектуудад хамааралтай байх боломжтой.
29.1.6.хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх;	Шаардлага хангасан.
29.1.7.бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх;	Эшлэлийг хийсэн.
29.1.8.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад удирдлага болгох, харгалзан үзэх нөхцөл байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журам;	Шаардлага хангасан.
29.1.9.шаардлагатай тохиолдолд эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын төрөл, хэмжээ, хуулийн хүчин төгөлдөр болох хугацаа, хууль буцаан хэрэглэх тухай заалт, хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт, бусад хуулийн зүйл, заалтыг хүчингүй болсонд тооцох, хасах заалт;	-Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах. -Хуулийн төслийг Улсын Их Хурлын 2021 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын дараалалд орсон тул хуулийн төслийн 20 дугаар зүйл дэх дагаж мөрдөх хугацааг 2022 оны 1 дүгээр сар байгааг боломжит хугацаагаар хойшлуулах.
29.1.10.шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулсан байх;	Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль, Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль, Зээлийн мэдээллийн тухай хууль, Банк, Банк бус санхүүгийн байгууллагын тухай хууль, Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуульд холбогдох нэмэлтийг оруулах.
Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан Хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага	

30.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томъёог хэрэглэх;	Хуулийн төслийн 6.3.8 дахь заалтын гэрээний нөхөн төлбөр, 16.1.11 дахь заалтын зээлжилтийн оноо өгөх эрх бүхий байгууллага гэснийг хууль тогтоомжид заасан нэр томъёонд нийцүүлэх.
30.1.2.нэг нэр томъёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх;	"Шүүхийн бус журмаар өр барагдуулах үйл ажиллагаа" гэснийг хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалтад тодорхойлсон байх бөгөөд үүнээс цааш "өр барагдуулах үл ажиллагаа" гэж томъёолсон байх тул "шүүхийн бус журмаар өр барагдуулах үйл ажиллагаа" гэх нэр томъёог хэрэглэх;
30.1.3.үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих;	Шаардлага хангасан.
30.1.4.хүч оруулсан нэр томъёо хэрэглэхгүй байх;	Шаардлага хангасан.
30.1.5.жинхэнэ нэрийг ганц тоон дээр хэрэглэх.	Шаардлага хангасан.

3.3."Хүлээн зөвшөөрөгдөх байдал" шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

Монгол Улсад 11 арилжааны банк үйл ажиллагаа эрхэлж байна. 2021 оны 2 дугаар улирлын байдлаар Монгол Улсад нийт 536 банк бус санхүүгийн байгууллага, үүнээс 457 нь Улаанбаатар хотод үйл ажиллагаагаа явуулж байна. Харин нийт 536 банк бус санхүүгийн байгууллагаын 497 нь зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байна. Тэгвэл үүний 418 нь Улаанбаатар хотод үйл ажиллагаагаа явуулж байна. Эдгээр банк, банк бус санхүүгийн байгууллагууд дотоод бүтэц дэх хуульчаар дамжуулан шүүх болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд оролцдог байна.

Эрхийн улсын бүртгэлд бүртгэгдсэн нийт үл хөдлөх хөрөнгийн барьцааны гэрээний мэдээллээс харахад, 2020 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн байдлаар 23,983 үл хөдлөх хөрөнгө барьцаалагч иргэн 56,996 үл хөдлөх хөрөнгийн барьцааны гэрээ, харин тодорхой тусгай зөвшөөрөлгүй 4137 хуулийн этгээд 91,988 барьцааны гэрээ байгуулсан байгаа нь тогтмол, ашиг олох зорилгоор иргэдийн үл хөдлөх хөрөнгийг барьцаалан өндөр хүүтэй зээлийн үйл ажиллагаа явуулж байгааг харуулж байна. 4137 хуулийн этгээд дотор компани зээл олгож байгаагаас гадна, төрийн байгууллага, сангаас олгосон бага хүүтэй зээл орсон байгаа болно.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд бүртгэгдсэн үл хөдлөх эд хөрөнгө барьцаалан олгосон 150 орчим гэрээг судлан үзэхэд, зээлийн гэрээнд нийтлэг байдлаар зээлдэгчийн эрх ашгийг ноцтой зөрчсөн, зээлдүүлэгч талаас урьдчилан тогтоож, байнга хэрэглэсэн стандарт нөхцөлүүд байна.

Тухайлбал, зээлийн гэрээний үүргээ биелүүлэхгүй, эсхүл хугацаа хэтрүүлсэн бол олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, цахимаар нэр хүндэд нь халдах, давагдашгүй хүчин зүйлийн

улмаас гэрээний үүргээ зээлдэгч биелүүлж чадаагүй нь тус үүргийг биелүүлэхийг хойшлуулах, чөлөөлөх үндэслэл болохгүй, *зээлдэгч нас барсан тохиолдолд өвлөгч өрийг төлөх үүрэгтэй байх, хэрэглээний зориулалтаар зээл олгосон боловч зээлдэгчээс тайлан, мэдээ авах, газар дээр нь хяналт шалгалт хийх эрх зээлдүүлэгчид байх*, нотариатын зардлыг зээлдэгч хариуцах, хүчингүй болсон хуулийн заалт иш татсан гэх зэрэг болно.

Зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлгүй компаниуд зээлийн гэрээг тогтмол байгуулж өндөр хүү, алданги, нэмэгдүүлсэн хүү, торгууль, шимтгэл авахын зэрэгцээ зээлдэгчийн бусад эрх ашгийг зөрчсөн стандарт нөхцөлийг гэрээндээ оруулсан байгаагаас энд түүвэрлэн хүргэж байна.

- Зээлдэгч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд Зээлдэгчийн хувийн болон бизнесийн нэр хүндэд халдах, шаардлагатай гэж үзвэл Хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн цахим сүлжээнд хэвлэн нийтлэх хүртэл арга хэмжээг авах, эсхүл зээлдэгч гэрээнд заасан төлбөр хийх хугацааг хэтрүүлсэн зээлдүүлэгчээс тавьсан шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд зээлдүүлэгч түүний бизнесийн болон хувийн нэр хүндэд халдах олон нийтэд мэдээлэх арга хэмжээ авна гэх байдлаар Зээлдүүлэгчийн эрхэд хамааруулан тусгажээ.
- Зээлийн зориулалт нь хувийн хэрэглээний байх боловч зээлдэгчид тайлан мэдээ гаргах, шалгуулах үүргийг тусгасан байна. Тухайлбал, Зээлийн ашиглалт түүний үр дүнгийн талаар зээлдүүлэгчид мэдээлэх зээлтэй холбогдсон асуудлаар зээлдүүлэгчээс шаардсан тайлан, мэдээг хугацаанд нь шаардлагын дагуу үнэн зөв саадгүй гаргаж өгөх тэдгээрийг *газар дээр нь хянаж шалгах боломж нөхцөлөөр хангах* гэж заасан байна. Эдгээр зээлийн гэрээ нь зориулалтын хувьд хэрэглээний зээл мөртлөө зориулалтын дагуу ашиглахаас өөрөөр ашиглахыг хориглоно гэж, түүнчлэн хяналт шалгалт хийж, тайлан мэдээ авахаар байгаа нь зээлдэгчийн эрх ашиг, хувийн байдалд нь халдсан шинжтэй байна.
- Зээлдэгчийн үүрэг хэсэгт зээлийн болон баарьцааны гэрээг нотариатаар батлуулах, зардлыг нь хариуцуулахаар заасан байна.

Нотариатын үйлчилгээний хөлс, зардлын хэмжээг батлах тухай Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2011 оны 123 тоот тушаалын хавсралтад зааснаар бүх төрлийн гэрээ, хэлцэлийг үнийн дүнгээс хамаарч 1 саяас доош үнийн дүнтэй бол 0.5 хувиар, 1-10 сая төгрөгийн үнийн дүнтэй гэрээ бол 10,000 төгрөг, 10-25 саяын үнийн дүнтэй гэрээ бол 25,000 төгрөг төлөхөөр заасан.

- Монгол Улсын Иргэний хуульд заасан нөхцөл бий болсон (Тухайлбал, зээлдэгч нас барах, эрх зүйн чадамжгүй болох, сураггүй алга болсонд тооцогдох зэрэг тохиолдолд) энэхүү гэрээг үндэслэн зээлдэгчийн өв залгамжлагч нь үндсэн зээл, зээлийн хүү, нэмэгдүүлсэн хүү, зээлтэй холбоотой гарсан бусад төлбөр зардлыг бүрэн хариуцан барагдуулах гэж гэрээнд заасан байна.

Гэтэл Иргэний хуулийн 535 дугаар зүйлд зааснаар “Өв хүлээн авсан өвлөгч буюу энэ бүлэгт заасан журмаар эд хөрөнгийг шилжүүлэн авсан төрийн байгууллага нь өвлүүлэгчийн гүйцэтгэвэл зохих үүргийг өвлөн авсан эд хөрөнгийн хэмжээнд хүлээнэ” гэж заасныг

зөрчиж байна. Өөрөөр хэлбэл өвлөгч өвлөн авсан эд хөрөнгийн хэмжээнд хариуцах нь Иргэний хуулийн суурь зарчим болно.

Түүнчлэн Иргэний хуулийн 536 дугаар зүйлд зааснаар өвлүүлэгчийн үүрэг гүйцэтгүүлэгч гомдлын шаардлагыг өв нээгдсэн өдрөөс хойш нэг жилийн дотор өвлөгч, нотариат, эсхүл эд хөрөнгийг шилжүүлэн авсан төрийн байгууллагад гаргах, улмаар гомдлын шаардлагын хариу авсан, эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаа дууссанаас хойш нэг жилийн дотор нэхэмжлэлээ шүүхэд гаргах зохицуулалт үйлчилдэг.

Үүнээс гадна, өдрийн зээлийн тухайд, сарын 10-15 хувийн хүүтэй зээлж, үндсэн зээл, хүүг урьдчилан бодож, өдөр өдөрт нь нийт дүнг хувааж, өдөр өдөрт ногдох хүү, үндсэн зээлийг урьдчилан өдөр бүрт нь авдаг. Зээлийг ашигласны хариуд хүүг төлдөг зарчим байдаг ч анх авсан зээлийг бүрэн ашиглаагүй байхад үндсэн зээл, хүүг урьдчилан хасч төлдөг, маш өндөр хүүтэй энэхүү зээлийг зах худалдааны төвүүдэд жижиглэн худалдаа эрхлэгч нар ихэвчлэн авч, үндсэн зээл, хүүгээ тухайн өдрөө төлөхгүй тохиолдолд барааг нь авах, орлогыг нь хураах, эсхүл дарамтлах зэргээр зээлдэгчтэй харьцаж, бусад эрхийг нь ноцтой хохироосоор байна. Энэхүү өдрийн зээлээс болж Хархорин зах дээр наймаа эрхэлдэг 20 настай бүсгүй амиа хорлосон²⁴ гэх мэдээлэл ч байна.

Хархорин захын 20 худалдаа эрхлэгчээс авсан асуулгын хариултаас үзэхэд, тэдний 8 нь өдрийн зээл авсан, авч байсан байна.

Өдрийн зээл нь сарын 10-12 хувийн хүүтэй байгаа талаар асуулгад бөглөсөн байна.

Өдрийн зээлийн хүүг бодохдоо үндсэн зээл, сарын хүүг нэмээд 30, эсхүл 22 хоногт хувааж өдөр бүр төлөх мөнгөн дүнг тооцоолдог байна.

Жишээ нь, 1 сая төгрөгийг 12 хувийн хүүтэй зээлсэн гэж бодвол, 1 сая 120 мянган төгрөгийг 30, эсхүл ажлын 22 хоногт хувааж өдөр бүрийн дүнг гаргаж, өдөр бүрээр төлүүлдэг байна. Мөн хугацаандаа төлж чадахгүй бол хоногийн 0.5 хувийн алданги бодогддог байна.

Түүнчлэн зээлийн хэмжээний хувьд 1-5 сая төгрөгийн хооронд байна.

Гэрээ байгуулахдаа нотариатаар баталгаажуулж, лангуу түрээслэсэн бичгийг хавсарган, нотариатын зардлыг зээлдэгчээр төлүүлдэг байна.

Мөн зээлдүүлэгчийн зүгээс дарамтлах, нэр хүндэд нь халдах, гэрт, ажилд нь байнга очих, утсаар байнга залгах байдлаар зээлдэгчийн бусад эрхэд халдаж харьцдаг байна.

Иймд зээлдэгчтэй харьцах харилцаанд зээлдэгчийн бусад эрхийг ноцтой зөрчсөн заалтыг зээлийн гэрээнд оруулах, эсхүл зээлдэгчтэй зүй бусаар харьцаж бусад эрхэд нь халдсаар байх тул энэхүү хуулийн төслийн 7 дугаар зүйл дэх зээлдэгчтэй харьцах стандарт шаардлагатай байгааг харуулж байна.

²⁴Мөн тэнд.

Хуулийн төслийн 7 дугаар зүйл дэх зээлдэгчтэй харьцах стандарт болон шүүхийн бус журмаар өр барагдуулах үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт бий болгохыг хүлээн зөвшөөрөх эсэхийг иргэд, олон нийтийн дунд цахимаар санал асуулга явуулахад 45 оролцогч оролцсон болно.

Асуулгын дүнгээс үзэхэд, 45 оролцогчийн 84.4 хувь нь ямар нэгэн хэмжээгээр зээл авч байсан бол асуулгад оролцогчдын 52.8 хувь нь зээлдүүлэгч мөнгөө нэхэхдээ дарамтлах, сүрдүүлэх, олон нийтэд зээлийн талаар тараах, доромжлох зэргээр бусад эрхэд нь халдаж байсан гэж, 44 хувь нь үгүй гэж, үлдсэн 3.2 хувь нь мэдэхгүй гэж хариулсан, мөн хуулийн төслийн 7 дугаар зүйл дэх зээлдэгчээс өр нэхэх стандартыг 93.3 хувь нь дэмжсэн байх бөгөөд 93.2 хувь нь уг хуулийн төсөл дэх шүүхийн бус журмаар өр барагдуулах үйл ажиллагааг бий болгохыг дэмжсэн байна.

Түүнчлэн судалгаанд оролцогчид зээлийн гэрээтэй холбоотойгоор шүүх болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагатай харьцаж байсан дундаж хугацааг 2 жил гэж хариулсан байна.

3.4.“Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

Хууль тогтоомжийн төслийн үр нөлөө үнэлэх аргачлалд заасан дараах асуултад хариулах замаар хуулийн төслийг бүхэлд нь үнэлж, хуулийн төслийн зохицуулалт өөр хоорондоо болон хүчин төгөлдөр үйлчилж байгаа бусад хуульд нийцэж байгаа эсэхийг шалгах байдлаар уялдаа холбоог тогтоохыг зорьлоо.

1.Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх.

Хуулийн төсөл нь хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хэрэгцээ ,шаардлагад нийцсэн.

2.Хуулийн төслийн “Хууль тогтоомж” гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх.

Хуулийн төслөөр “Хууль тогтоомж” гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарч байна.

3.Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томьёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томьёотой нийцэж байгаа эсэх.-

Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томьёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томьёотой нийцэж байна.

4.Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх.

Хуулийн төслийн 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсэгт зээлжилтийн оноо өгөх байгууллага гэснийг Зээлийн мэдээллийн тухай хуульд заасан нэр томьёотой нийцүүлэх.

Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн заалттай нийцэж байна.

5.Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх.

Хуулийн төслийн зүйл, заалт өөр хоорондоо давхардсан зохицуулалт

- 11.1.2 болон 11.1.3 дахь заалт
- 16.1.2 болон 16.1.12 дахь заалт
- 16.1.10 болон 16.1.14 дахь заалт

Хуулийн төслийн зүйл, заалт бусад хуулийн заалттай давхардсан зохицуулалт байхгүй байна.

6.Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх.

Хуулийн төслийн дагуу байгуулагдах өр барагдуулах алба болон бусад зээлдүүлэгч, түүний төлөөлөгч, зээлдүүлэгчийн ажилтанд зээлдэгчтэй харилцахдаа хуулийн төсөлд заасан стандарт /хуулийн төслийн 7 дугаар зүйл/-ыг баримтлах нь зүйтэй эсэхийг дахин нягтлах.

7.Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх.

Өр төлбөртэй этгээдийн хамааралтай этгээд гэж хэн болох, тэдгээртэй харьцах стандарт, өр төлбөртэй этгээд хуульч, төлөөлөгчөө томилвол тэдгээртэй харьцах, өр төлбөртэй этгээдтэй харьцахгүй байх;

Бүртгэлийн гэрчилгээний хугацаа, бүртгүүлэхэд бүрдүүлэх баримт бичиг, бүртгэлийг түдгэлзүүлэх, сунгах, сануулах, хүчингүй болгох нөхцөлийг нэмэх;

Нэр томьёоны хэсэгт өр төлбөртэй этгээд, хамааралтай этгээд, өр төлбөр барагдуулагч /зээлдүүлэгч өөрөө, түүний төлөөлөгч, зээлдүүлэгчийн өр барагдуулах дотоод бүтцийн ажилтан, өр барагдуулах албаны ажилтан/, өр барагдуулах алба, өр төлбөр гэх нэр томьёог ялгаж хуульчлах.

8.Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх. -

9.Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх. -

Шүүхийн бус журмаар өр барагдуулах албаны үйл ажиллагааг ашгийн төлөө хувийн эрх зүйн хуулийн этгээд төрийн бүртгэлд бүртгүүлсний үндсэн дээр эрхлэх, тэдгээрийг хянах, зээлдэгчийн эрхийг ноцтой зөрчвөл холбогдох хариуцлагыг тооцох тул төрийн бус байгууллагаар уг бүртгэл, хяналтыг гүйцэтгүүлэх боломжгүй юм.

10.Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх. -

Хуулийн төсөлд энэ талаарх зохицуулалт тусгагдаагүй.

11.Тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгасан эсэх. -

Хуулийн төсөлд энэ талаарх зохицуулалт тусгагдаагүй.

12.Хуулийн төслийн зүйл, заалт жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх.

Хуулийн төсөл нь жендэрийн эрх тэгш байдлын асуудлыг хөндөөгүй.

13.Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх.

Хуулийн төсөлд энэ талаарх зохицуулалт тусгагдаагүй.

14.Хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх.

Хуулийн төсөлд энэ талаарх зохицуулалт тусгагдаагүй.

15.Хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх.

Хуулийн төслийг дагалдах хуулийн төсөлд энэ талаарх зохицуулалт тусгагдаагүй байна. Түүнчлэн хуулийн төслийн 18 дугаар зүйлийн 18.2-18.4 дэх хэсэгт заасан арга хэмжээ, хариуцлагыг заахдаа сануулах, зөрчлийг арилгах хугацаатай үүрэг өгөх арга хэмжээг ямар тохиолдолд авах, бүртгэлийн гэрчилгээг түдгэлзүүлэх нөхцөл, хүчингүй болгох нөхцөл талаар тодорхой тусгах.

ДӨРӨВ. ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГӨХ

Үр дүнг үнэлж, зөвлөмж өгөх үе шатыг аргачлалын 5 дахь хэсэгт заасны дагуу дараах дарааллаар хийлээ:

4.1.үр дүнг баримтжуулах;

4.2.үнэлэх;

4.3.зөвлөмж өгөх.

4.1.Үр дүнг баримтжуулах: Шүүхийн бус журмаар өр барагдуулах үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх ажиллагааг “зорилгод хүрэх байдал”, “ойлгомжтой байдал”, “хүлээн зөвшөөрөгдөх байдал”, “харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд холбогдох шалгах хэрэгслийг ашиглан хийсэн бөгөөд ийнхүү үр нөлөөний үнэлгээг хийхдээ шаардлагатай хууль тогтоомж, бусад эрх зүйн акт болон хамаарал бүхий холбогдох мэдээлэл, тоо баримт зэрэг материалыг цуглуулж ашиглан, эдгээр материалын жагсаалтыг үнэлгээний тайланд хавсаргав.

4.2.Дүгнэлт: Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх ажиллагааг аргачлалд заасан 4 шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн ба шалгуур үзүүлэлт тус бүрээр дүгнэвэл:

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн дүгнэлт:

Энэ шалгуур шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалт нь хуулийн төсөл боловсруулах болсон хэрэгцээ, шаардлагад нийцсэн эсэхийг үзэл баримтлалд тусгасан хэрэгцээ, шаардлага бүрээр дүгнэвэл:

/Үнэлгээний тайлангийн 13-17 хуудсанд үнэлж, дүгнэлт өгсөн байгаа болно./

“Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн дүгнэлт:

Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд Хууль тогтоомжийн тухай хуулийн 29, 30 дугаар зүйлд заасан шаардлага, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шалгуурыг хангасан эсэхэд үнэлгээ хийж холбогдох дүгнэлтийг тайлангийн 3.2. дахь хэсэгт /18-20 дугаар хуудас/ тодорхой тусгасан болно.

"Хүлээн зөвшөөрөгдөх байдал" шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн дүгнэлт:

/Үнэлгээний тайлангийн 20-22 дугаар хуудсанд үнэлж, дүгнэлт өгсөн байгаа болно./

"Харилцан уялдаа" шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн дүгнэлт:

/Үнэлгээний тайлангийн 23-25 дугаар хуудсанд үнэлж, дүгнэлт өгсөн байгаа болно./

4.3.Зөвлөмж:

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт Баялаг бүтээгч хувийн хэвшлийг дэмжсэн Арилжааны багц хууль боловсруулахаар, түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 21 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Зээлийн хүүг бууруулах стратеги”-ийн 2.2.1-д "зээлийн эрсдэлийн зардлыг бууруулах, хэрэг, маргааныг зардал багатай шийдвэрлэх чиглэлээр эрх зүйн орчныг боловсронгуй болгох” гэж, мөн Монгол Улсын Их Хурлын 2020 оны “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2021 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” 32 дугаар тогтоолын 3-д “санхүүгийн гэрээ, хэлцэлд оролцогч талуудын үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлж, тэдгээрийн хооронд үүссэн маргааныг шүүхээс богино хугацаанд үр дүнтэй шийдвэрлэх, барьцаалагчийн шаардах эрхийг хангуулах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд төлбөр авагчийн эрхийг хамгаалах чиглэлээр хууль, эрх зүйн орчныг сайжруулах” гэж, мөн оны “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 24 дүгээр тогтоолын хавсралтын 3.1.8-д "Банк, санхүүгийн систем дэх чанаргүй зээлийг шуурхай, зардал багатай шийдвэрлэх хууль, эрх зүйн шинэчлэл хийж, санхүү, эдийн засгийн хүндрэлийг богино хугацаанд даван туулж, эдийн засгийн тогтвортой, хүртээмжтэй өсөлтийг хангах бодлого хэрэгжүүлэх" гэж, түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 2021 оны “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай” 12 дугаар тогтоолын хавсралтын 73-т “Шүүхийн бус журмаар өр барагдуулах үйл ажиллагааны тухай хуулийн төслийг боловсруулж, УИХ-д

өргөн мэдүүлэх" гэж тус тус заасан тул эдгээр зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор хуулийн төслийг боловсруулсан байна.

Дээрх дүгнэлтэд үндэслэн хуулийн төслийн зарим зохицуулалтыг тодорхой болгох, холбогдох хуульд нийцүүлэх, зарим зохицуулалтыг өөрчлөх зэргээр хуулийн төслийг хуулийн төслийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах улмаар хуулийн төслийг боловсронгуй болгох, чанарыг сайжруулах зорилгоор дараах зөвлөмжийг хууль санаачлагчид өгч байна.

1.Хуулийн төслийн 8 дугаар зүйлд өр төлбөртэй этгээдэд мэдэгдэх хугацаа, өр барагдуулах алба зээлдүүлэгчид хүргүүлэх, зээлдүүлэгч хариу өгөх хугацааг хүндэтгэн үзэх шалтгаанаар сунгах нөхцөл, хугацаа дууссан бол хэрхэх, хэрэв тус ажиллагаа амжилтгүй болвол, эсхүл зээлдүүлэгчийн хүсэлтээр өр барагдуулах үйл ажиллагааг зогсоож шүүхэд хандаж болох талаарх зохицуулалтыг нэмэх;

2.Хуулийн төсөлд "зээлжилтийн оноо өгөх эрх бүхий байгууллагатай мэдээлэл нийлүүлэх талаарх гэрээ байгуулах" гэж томъёолсныг зээлийн мэдээллийн санд мэдээлэл нийлүүлэх гэж өөрчлөх нь зүйтэй байна. Түүнчлэн дагах хуулийн төсөл боловсруулахдаа Зээлийн мэдээллийн тухай хуульд заасан мэдээлэл нийлүүлэгч гэх тодорхойлолтод өр барагдуулах албыг нэмэх шаардлагатай;

3. Хэрэглэгчийн эрхийн асуудал нь хуулийн этгээд зээлдэгч байх тохиолдолд, эсхүл бизнесийн зээлд хамаарах эсэхийг дахин нягтлах;

4.Өр төлбөр, өр төлбөртэй этгээд, өр төлбөр барагдуулагч, өр барагдуулах алба, хамаарал бүхий этгээд гэх нэр томъёог хуульчлах;

5.Өр төлбөртэй этгээд хуульч, төлөөлөгчөө томилвол тэдгээртэй харьцах, өр төлбөртэй этгээдтэй харьцахгүй байх асуудлыг нэмж тусгах;

6.Өр төлбөртэй этгээдийн хамаарал бүхий этгээд гэж хэн болох, тэдгээртэй харьцах стандартыг тогтоох;

7.Хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалтад өр барагдуулах үйл ажиллагаа гэснийг тодорхойлсон байх бөгөөд мөн төслийн 5 болон 9 дүгээр зүйлд зааснаар өр барагдуулах үйл ажиллагаа эрхлэх этгээд нь Санхүүгийн зохицуулах хороонд бүртгүүлэхээр байна. Иймд өр барагдуулах бүртгэлд бүртгэгдсэн этгээдээс гадна зээлдүүлэгч, түүний төлөөлөгч, банк, банк бус санхүүгийн байгууллагын дэргэдэх өр барагдуулах дотоод бүтэц ч мөн адил зээлдэгчтэй харьцахдаа энэ хуулийн төсөлд тусгагдсан хязгаарлалтыг дагаж мөрдөх эсэх талаар дахин нягтлах;

8.Бүртгэлийн гэрчилгээ нь хугацаатай эсэх, *хугацаатай бол хэдэн жилээр олгох, хэрхэн сунгуулах, сунгах, түдгэлзүүлэх нөхцөлийн* талаар зохицуулалт нэмэх;

9.Бүртгүүлэхээр өргөдөл гаргахад хавсаргах баримт бичгийг хуулийн төслийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт нэмж хуульчлах, тухайлбал, улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, хөрөнгийн эх үүсвэрийг нотлох баримт, сургалтад хамрагдсан нотлох баримт, ажлын байрыг нотлох баримт, цахим системтэй талаарх нотлох баримт, татварын нэгдсэн системд холбогдсон кассын машин, хэвлэх төхөөрөмжтэй байх нотлох баримтыг хавсаргах, түүнчлэн хуулийн төслийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэгт бүртгэх байгууллагын баталсан

журмын дагуу өргөдлийг гаргахыг заасан тул бүртгэх байгууллага журам гаргах тусгайлан эрх олгосон зохицуулалтыг нэмэх;

10.Хуулийн төслийн 7 дугаар зүйл дэх хязгаарлалтыг зөрчсөн тохиолдолд хэрхэн хариуцлага хүлээх талаар дагах хуулийн төсөлд оновчтой тусгах;

11.Шүүхийн өмнөх шатан дахь өр барагдуулах алба нь банк, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршооноос бусад мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгчийн бүртгэлд бүртгүүлээгүй байнга, ашгийн төлөө зээлийн үйл ажиллагаа эрхлэгч зээлдүүлэгчид үйлчилгээ үзүүлэхгүй талаар зохицуулалт тусгаж, зөрчвөл холбогдох хариуцлага тооцохыг дагах хуулийн төсөлд хуульчлах;

12.Хуулийн төсөлд зээлжилтийн оноо өгөх эрх бүхий байгууллагатай мэдээлэл нийлүүлэх талаарх гэрээ байгуулах гэснийг зээлийн мэдээллийн санд мэдээлэл нийлүүлэх гэж өөрчлөх нь зүйтэй байна. Түүнчлэн дагах хуулийн төсөл боловсруулахдаа Зээлийн мэдээллийн тухай хуульд заасан мэдээлэл нийлүүлэгч гэх тодорхойлолтод өр барагдуулах албыг нэмэх шаардлагатай;

13.Хуулийн төслийн 16 дугаар зүйлийн 16.1.8 дахь заалтад "гэрээнд заагаагүй төлбөрийг өр төлбөртэй этгээдээс шаардах" гэснийг "гэрээнд заагаагүй төлбөрийг өр төлбөртэй этгээдээс шаардахгүй байх" гэж өөрчлөх;

14.Хуулийн төслийн 16 дугаар зүйлийн 16.1.10, 16.1.14 дахь заалтыг нэгтгэж, 16.1.7 дахь заалттай уялдааг хангах, өөрөөр хэлбэл, дуу, дүрсний бичлэг хийж баримтжуулсанаа цахим санд байршуулдаг байхаар томьёолох;

15.Хуулийн төслийн 16 дугаар зүйлийн 16.1.2, 16.1.12 дахь заалтыг нэгтгэх, мөн үүн дээр 16.1.16 дахь заалтыг дарааллан байршуулах. Учир нь утга агуулгын хувьд мэдээлэл хүргүүлэх үүрэг юм;

16.Хуулийн төслийн 14 дүгээр зүйл нь ажилтанд хамаарах шаардлага байх тул 14.2 дахь хэсэгт зөвхөн эрх бүхий албан тушаалтанд тавигдах шаардлага байдлаар хязгаарлахгүй, ажилтанд хамаарах шаардлагыг мөн зүйлийн 14.3 дахь хэсэгт эшлэх;

17.Хуулийн төслийг Улсын Их Хурлын 2021 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын дараалалд орсон тул хуулийн төслийн 20 дугаар зүйл дэх дагаж мөрдөх хугацааг 2022 оны 1 дүгээр сар байгааг боломжит хугацаагаар хойшлуулах.

18.Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль, Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Зээлийн мэдээллийн тухай, Банкны тухай, Банк бус санхүүгийн байгууллагын тухай, Хадгаламж, зээлийн хоршооны хуульд нэмэлт оруулах хуулийн төсөл боловсруулах.

---oOo---

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ:

I.Хууль тогтоомж, эрх зүйн акт

- 1.Хууль тогтоомжийн тухай хууль
- 2.Иргэний хууль
- 3.Зээлийн мэдээллийн тухай хууль
- 4.Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль
- 5.Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль
- 6.Банкны тухай хууль
- 7.Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль
- 8.Хадгаламж, зээлийн хоршооны тухай хууль

II.Бусад ашигласан материал

- 1.Хууль зүй, дотоод хэргийн сайдын баталсан Шүүхийн бус журмаар өр барагдуулах үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал
- 2.Шүүхийн бус журмаар өр барагдуулах үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн төсөл /2021 оны 07 дугаар сарын байдлаарх/
- 3.Хуулийн төслийн таницлуулга
- 4.Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд бүртгэгдсэн үл хөдлөх эд хөрөнгө барьцаалан олгосон зээлийн гэрээнд хийсэн дүн шинжилгээ
- 5.Банк, банк бус санхүүгийн байгууллагын талаарх статистик мэдээлэл
- 6.Иргэдээс авсан асуулгын судалгаа
- 7.Төрөөс мөнгөний бодлогын талаар 2021 онд баримтлах үндсэн чиглэлийн төсөл, Монголбанк, 2020 он.

III. Интернет эх сурвалж

- 1.<http://www.legalinfo.mn>
- 2.<http://www.judoinstitute.mn/main/244--2019-3-.html>
3. https://elaw.klri.re.kr/eng_mobile/viewer.do?hseq=47919&type=sogan&key=40
- 4.<http://www.japaneselawtranslation.go.jp/law/detail/?printID=&re=02&ky=additional+tax&ia=03&page=8&la=01&vm=02&lvm=02&id=1956>